



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 2/417

Арвайхээр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 22 дугаар зүйлийн 22.1, 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан “Журам батлах тухай” А-230/127 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Усны тоо бүртгэл, усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоож, тэмдэгжүүлэх ажлын хэсгийг бүрэлдэхүүнийг байгуулж хавсралтаар баталсугай.

2. Усны тоо бүртгэл, усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоож, тэмдэгжүүлэх ажлыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, дүн мэдээг 2023 оны 11 дүгээр сарын 20-ны дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Баясгалан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

Аймгийн Засаг даргын 2023 оны 26 дугаар
сарын 22-ны өдрийн 4/417 дугаар
захирамжийн хавсралт
хавсралт



УСНЫ ТОО БҮРТГЭЛ, УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР, УСНЫ ЭХ ҮҮСВЭРИЙН
ОНЦГОЙ БОЛОН ЭНГИЙН ХАМГААЛАЛТЫН БҮСИЙГ ТОГТООЖ,
ТЭМДЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН ДАРААХ БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Г.Баясгалан (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын
хүрээний агентлаг Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын дарга)

Гишүүд:

Ц.Хашхүү (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын
хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын Газрын удирдлагын
хэлтсийн дарга)

Ч.Бат-Өлзий (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн мэргэжилтэн)

Ц.Болдбаатар (аймгийн Засаг даргын эрхлэх
асуудлын хүрээний агентлаг Байгаль орчин, аялал
жуулчлалын газрын мэргэжилтэн)

Б.Энхсүрэн (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын
хүрээний агентлаг Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын мэргэжилтэн)

Б.Даваацэрэн (аймгийн Засаг даргын эрхлэх
асуудлын хүрээний агентлаг Байгаль орчин, аялал
жуулчлалын газрын мэргэжилтэн)

Ш.Дуламжаргал (Онги, Таац голын сав газрын
захиргааны ахлах мэргэжилтэн)

О.Алтанчимэг (Онги, Таац голын сав газрын захиргааны
ахлах мэргэжилтэн)

Сумдын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны
асуудал хариуцсан мэргэжилтэн

Сумдын Газрын даамал

-оОо-